



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2016 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран 2016 оны 09 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн хуульчдын холбоонд бүртгэлтэй нийт 100 гаруй хуульчдад сургалт зохион байгуулж, партизаны талбайд иргэдэд хууль зүйн үнэгүй зөвлөгөөг өгч ажиллалаа.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, захиргааны актад тавигдах шаардлагыг хангасан шийдвэрүүдийг хянуулах бүртгүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан 1 ширхэг актыг хүчингүй болгож Хууль зүйн яаманд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Прокурорын газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Прокурорын газар, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын албан хаагчид, багийн Засаг дарга нар, нийгмийн ажилтнуудыг хамруулан зөвлөгөөн зохион байгуулж, зөвлөгөөнөөс гаргасан уриалгыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

Сэлэнгэ аймагт 50 мвт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг байгуулах ажлыг концессын зарчмын дагуу хөрөнгө оруулах зорилгоор Монгол Улсын Сэлэнгэ аймаг, БНХАУ-ын “Жин Хуа групп” ХХК хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг үзэглэлээ. Энэхүү харилцан ойлголцлын хүрээнд Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дулааны цахилгаан станц барихтай холбоотой баримт бичиг, зөвшөөрлийн асуудлыг судлан хариуцаж, дулааны цахилгаан станцын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад хэрэглэгчийн талаарх шаардлагатай тоо баримт, мэдээллээр хангана. “Жин Хуа групп” ХХК нь Сэлэнгэ аймагт ажиллах хүчний сургалт, бэлтгэл ажлыг ханган, дулааны цахилгаан станц барих барилга угсралтын үйл ажиллагааг бүрэн хариуцаж, барилгын ажил эхлэх зөвшөөрөл бүрдсэний дараа 24 сарын хугацаанд уг станцыг барьж ашиглалтанд хүлээлгэн өгнө гэсэн тохиролцоонд хүрсэн байх юм байна.

АНУ-ын Элчин Сайдын яамны консулын хэлтсийн дарга Жэйсон П. Спэлбэргы, АНУ-ын Төрийн департамент аюулгүйн албаны тусгай ажилтан Жереми Т. Вайнштайн нар Сэлэнгэ аймагта ажиллалаа. Сэлэнгэ аймгийн хувьд АНУ-тай хамтран ажиллаж байгаагүй бөгөөд энэ уулзалт ярилцлага болон хных нь юм. Мөн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчидтай уулзаж, АНУ-д суралцах сонирхолтой хүүхдүүд америкийн виз гаргуулахад юунд ээранхаарах, ямар шаардлагыг хангасан байх зэргээр мэдээлэл өглөө.

Алтан гадас одонт ахмад багш Н. Аюу агсны нэрэмжит өсвөр үеийн кросс гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 10 дугаар сарын 24-ний өдөр болж өндөрлөлөө.

Анх удаа улсын хэмжээнд зохион байгуулж байгаа энэхүү тэмцээнд Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Говь-алтай, Дархан-Уул, Төв, Хэнтий, Өмнөговь, Сэлэнгэ, Дорноговь зэрэг 14 аймаг, 6 сум, Улаанбаатар хотын БТДу Сургууль, Алдар спорт хороо, Сонгинохайрхан дүүргийн нийт 302 тамирчид оролцож 5 зайн төрөлд 5 насны аггиллаар хурд хүчээ сорилоо.



Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1. Орон нутгийн төсвийн нэгдсэн мэдээ:

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Орон нутгийн төсвийн нийт орлого	12,100,431.7	9,248,892.3	76.4
Үүнээс: Аймгийн төсвийн орлого	9,460,176.9	7,268,450.5	76.8
Орон нутгийн төсвийн нийт зарлага	48,047,237.6	40,910,019.4	85.1
Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	11,218,053.6	8,442,040.3	75.3
- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2,008,460.1	985,149.8	49.1
- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	556,756.8	186,003.5	33.4
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	451,489.7	358,738.8	79.5
Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	4,789,973.1	2,011,255.5	42.0
Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,138,200.0	1,138,200.0	100.0
Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	28,254,305.1	28,254,305.1	100.0
- Ерөнхий боловсролын сургууль	14,698,136.4	14,698,136.4	100.0
- Хүүхдийн цэцэрлэг	7,197,413.0	7,197,413.0	100.0
- Эрүүл мэнд, спортын байгууллага	4,119,955.5	4,119,955.5	100.0
- Соёлын байгууллагуудын	1,899,186.5	1,899,186.5	100.0
- Газрын харилцаа кадастрын алба	154,666.9	154,666.9	100.0
- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	184,946.8	184,946.8	100.0
Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	28,254,305.1	27,952,489.5	98.9
- Ерөнхий боловсролын сургууль	14,698,136.4	14,396,320.8	97.9
- Хүүхдийн цэцэрлэг	7,197,413.0	7,197,413.0	100.0
- Эрүүл мэнд	3,247,513.3	3,247,513.3	100.0
- Өрхийн эмнэлэг	367,164.0	367,164.0	100.0
- Спортын байгууллага	505,278.2	505,278.2	100.0
- Соёлын байгууллагуудын	1,899,186.5	1,899,186.5	100.0
- Газрын харилцаа кадастрын алба	154,666.9	154,666.9	100.0
- Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	184,946.8	184,946.8	100.0
Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	2,073,975.1	1,887,787.5	91.0
Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,873,803.8	1,118,261.5	38.9
Аймгийн нийт ангилагдаагүй зардал	483,714.8	412,580.7	85.3
Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	229,045.2	190,540.2	83.2
Тусгай сангуудын зарлага	5,122,695.2	774,764.6	15.1

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2016	2016	2016-VIII
	VII- сар	VIII- сар	2016-VII
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 Талх, гурил, будаа			



СЭЛЭНГЭ АЙМАГ

	Гурил /савласан, кг/	1200	1200	100
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	100
	Нарийн боов /кг/	2300	2300	100
	Будаа /кг/	2200	2200	100
	Элсэн чихэр /кг/	1800	1800	100
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6000	5500	91.7
	Үхрийн мах /кг/	6500	6500	100.0
	Адууны мах /кг/	5300	5000	94.3
	Ямааны мах /кг/	5000	4800	96.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4500	4500	100.0
	Хиам /чанасан, кг/	9500	9500	100.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	800	800	100
	Сүү / савласан, л/	2500	2500	100
	Тараг /задгай, л/	1000	1000	100
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	10000	10000	100
	Айраг /л/	3500	3500	100
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	100
	Өндөг /ш/	300	300	100
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3400	3400	100
	Өөхөн тос /кг/	1500	1500	100
	Шар тос /кг/	9000	9000	100
	Масло /задгай, кг/	5000	5000	100
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1500	1000	67
	Лууван /кг/	1500	1500	100
	Манжин /кг/	1500	1500	100
	Байцаа /кг/	1500	1000	67
	Сонгино /кг/	2000	2000	100
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3000	3000	100
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	100
2	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1480	1480	100.0
	Бензин А - 92	1580	1580	100.0
	Дизелийн түлш	1690	1690	100.0

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Гэмт хэргийн талаар:

Аймгийн хэмжээнд энэ оны 9 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

- Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг 482 буюу 9.7 хувиар буурсан
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирол /сая.төг/ 949.4 буюу 3.6 хувиар буурсан

Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл:

- Хүнийг санаатай алах хэрэг 4 бүртгэгдэж -33.3 хувиар буурсан



СЭЛЭНГЭ АЙМАГ

- Бусдыг амиа хорлоход хүргэх 1 буюу 66.7 хувиар буурсан
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах 185 буюу 1.1 хувиар буурсан
- Хүчиндэх 14 буюу 75.0 хувиар өссөн
- Хулгайлах 119 буюу 20.7 хувиар буурсан
- Хувийн өмчийг хулгайлах 77 буюу 15.4 хувиар буурсан
- Мал хулгайлах 38 буюу 22.4 хувиар буурсан
- Дээрэмдэх 3 буюу 2 дахин өссөн
- Ойн хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 12 бүртгэгдэж 2 дахин өссөн
- Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг 60 буюу 22.4 хувиар өссөн

Үйлдэгдсэн онцлогоор нь авч үзвэл:

- Галт зэвсгээр 3 буюу 3 дахин өссөн
- Согтуугаар 193 буюу 7.2 хувиар өссөн
- Гэр бүлийн хүчихийлэл 36 буюу 5.9 хувиар өссөн тоон мэдээтэй байна.

Улсын бүртгэлийн талаар:

Улсын бүртгэлийн хэлтэс нь эхний 9 сарын байдлаар 1789 төрөлт, 338 гэрлэлт, 504 нас баралт, 6858 иргэнд цахим үнэмлэх 849 үндэсний энгийн гадаад паспорт, ОХУ-ын хавсралт 40673 ширхэг олголтыг хийж ажиллалаа.

Иргэний шилжилт хөдөлгөөн:

- Аймаг, хотруу шилжин явсан 2225, шилжин ирсэн 1590
- Сум дүүрэгт шилжин ирсэн 605
- Сум дүүрэгт шилжин явсан 548
- Баг хооронд шилжин ирсэн 1141
- Баг хооронд шилжин явсан 1099 шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэл эхний 9 сарын байдлаар 260 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 910 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамж 192195, үйлчилгээний хураамж 12205501 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны татвар 11699001 төгрөгийг төвлөрүүллээ.

Архивынталаар:

Төрийн архивын тасгийн гэрээт ажилтнуудын 9 дүгээр сарын ажлын мэдээг гаргаж Архивын ерөнхий газарт хүргүүллээ.

Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, аймгийн намын хороо, Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтэсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу лавлагаа мэдээлэл гаргаж, холбогдох хариуг хүргүүллээ.

“Мон энерги” ХХК-ийн гүйцэтгэсэн Шаамар сумын Дулаанхаан тосгоны цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл, “Есөн талын богд” ХХК-ийн гүйцэтгэсэн Сайхан суманд баригдсан ахуйн хийн цэнэглэх станцын барилгын ажлын гүйцэтгэл, “Эрчим өргөө” ХХК-ийн гүйцэтгэсэн Жавхлант сумын төвийн гэрэлтүүлгийн ажил, “Таван хан” ХХК-ийн гүйцэтгэсэн Сүхбаатар сумын цэнхэр байрнуудын засварын ажлын гүйцэтгэл зэрэг зураг төслийн баримтыг хүлээн авч бүртгэл акт үйлдэн хөмрөгт байрлууллаа.

Төрийн архивын АМС программд аймгийн Шүдэнзний үйлдвэр, Хүнсний үйлдвэр, Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар, Сумдын ахуйн үйлчилгээний төв, Сумдын Худалдаа бэлтгэлийн анги, Ойн аж ахуй, Сум дундын 20-р шүүх зэрэг хөмрөгүүдийн дансны мэдээллийг шивсэн.

АМС программд аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний удирдах газар, сумдын Худалдаа бэлтгэлийн анги, Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн нийт



СЭЛЭНГЭ АЙМАГ

Зхөмрөгийн 7 дансны 102 хадгаламжийн нэгжийн 8878 хуудасны баримтын мэдээллийг уншиж, заалт 7699, хүний нэр 24335, байгууллагын нэр 469, газарзүйн нэр 1086 шивж ашиглалтын хувьтай холбох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Ойн аж ахуй, Сумдын худалдаа бэлтгэлийн анги, сумдын Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн нийт Зхөмрөгийн 7 дансны 96 хадгаламжийн нэгжийн 5434 хуудсыг Photoshop программ ашиглан ашиглалтын хувь үүсгэлээ.

Сумдын ахуйн үйлчилгээний төвийн 1,3-р дансны 32 хадгаламжийн нэгжийн 1615 хуудас, Гурилын үйлдвэрийн комбинатын 21 хадгаламжийн нэгжийн 3166 хуудас нийт 53 хадгаламжийн нэгж, 4781 хуудсыг скайнедаж мастер хувь үүсгэлээ.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 217, тодорхойлолт 16, магадлагаа 27 гаргаж үйлчиллээ.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Эрүүл мэнд, хүүхэд залуучуудын талаар:

2016 оны 09 дүгээр сарын 15-17 өдрүүдэд аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч, сумын Эрүүл мэндийн төвийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч бага эмч, нярайн сувилагч нарт Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нярай судлалын зөвлөх эмч С.Энхтуяа “Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж” сэдвээр онол болон ажлын байрны сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр Эрүүл мэндийн сайдын зөвлөх С.Цэцэгсайхан Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаатай танилцаж, эмч мэргэжилтнүүдтэй уулзалт хийн тулгамдсан асуудлаар санал бодлоо солилцлоо.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, аймгийн Эрүүл мэндийн газар хамтран нэгдсэн эмнэлгүүд, сум дундын эмнэлэг, сум тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нарын дунд “Нярайн их эмч нарыг чадавхижуулах ажлын байран дах онол дадлага хосолсон” сургалтыг 2016 оны 09 дүгээр сарын 08-23-ны өдрүүдэд зохион байгуулж, 4 ээлжээр 36 эмчийг хамрууллаа.

2. Боловсрол, соёл урлагийн талаар:

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн хичээлийн шинэ жилийн нээлтийг зохион байгуулж, хичээл сургалт аймгийн хэмжээнд хугацаандаа бүрэн эхэлсэн. БСШУЯ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу 09 дүгээр сарын 01-ний өдөр “Монголын нууц товчоо” хичээл Монгол Улсын ерөнхийлөгчийн “Монголын бахархал” хичээлийг сурагчдад үзүүллээ.

Дэлхийн багш нарын болон Монголын багш нарын 50 дахь өдрийг угтан улсын тэргүүний сургууль, цэцэрлэгүүд, оны тэргүүний багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор бичлэг хийлгэж, DVD-д буулган сургууль цэцэрлэгүүдэд хүргүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Усан онгоцны загварын улсын аварга шалгаруулах насанд хүрэгчдийн тэмцээнийг Усан спортын холбоо, Мандал сумын улсын тэргүүний 1 дүгээр сургуультай хамтран зохион байгууллаа.

3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний талаар:

2016 оны 08-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 815 байсан бол 261 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 137 ажлын байранд 117 хүнийг



СЭЛЭНГЭ АЙМАГ

ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 195 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 764 боллоо.

Нийгмийн халамжийн сангаас 09 дүгээр сард 8189 иргэнд 729.4 сая төгрөгийг олгоод байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2430 иргэнд 340.0 сая төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1407 иргэнд 137.0 сая төгрөг, Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжинд 1570 иргэнд 100.0 сая төгрөгийг тус тус олголоо.

Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2000 эхэд 80.0 сая төгрөг, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжинд 43 иргэнд 16.0 сая төгрөг, эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 739 иргэнд 56.4 саятөгрөгийг тус тус олголоо.

Тав.Хүнс, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

2016 оны ургац хураалт цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан хураалтын ажил нэлээдгүй удаашрах төлөвтэй байна.

Аймгийн хэмжээнд 10-р сарын 3-ны байдлаар улаанбуудай 100,7 мянган га хурааж, га-гаас 16,9 цн буюу 170,6 мянган тн, бусад үр тариа 1031 га хурааж, га-гаас 15,1 цн буюу 1557 тн, тэжээлийн ургамал 4691 га-гаас 15,6 цн буюу 7323 тн, тосны ургамал 5240 га-гаас 5,9 цн буюу 3071 тн, төмс 2811 га хурааж, га-гаас 126 цн буюу 35303 тн, хүнсний ногоо 2033 га хурааж, га-гаас 129 цн буюу 26214 тн-ыг тус тус хураан авч байна.

Нийт ургац хураалтын ажил 63,3 хувь үүнээс улаанбуудай 71,2 хувь, тосны ургамал 22 хувь, тэжээлийн ургамал 86,3 хувь, төмс 86 хувь, хүнсний ногооны хураалт 79.9 хувьтай явагдаж байна.

Уламжлалболонзохионбайгууллагддаг “Намрынногоон өдрүүд-2016” нэгдсэнаргахэмжээнийхүрээнд “Алтан намар-2016” шинэургацынтөмс, хүнснийногооны, жимсжимсгэнэ, “Эрүүл хүнс-2016” аргахэмжээнд 9 сумын 40 гаруйногоочин 2000 тнтөмс, 3000 тнхүнснийногоо, 5000 ширхэгдаршилсанногоо, 1 тнзөгийнбалхудалдалж, 1,5 тэрбумтөгрөгийнборлуулалтхийлээ.

Төмсхүнснийногооныборлуулалтыг 7 дугаарсарын 20-оос хойшманайсумдуудУлаанбаатар хотындүүргүүдэдболонойролцоохаймагороннутагтааборлуултаахийжтөмсхүнснийногооны 60 орчимхувьбуюу 40,0мянгантн-ыгборлууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 дугаар тогтоолын дагуу хонины ноос, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 1950 малчны 553,1 мянган тонн-оос урамшууллын материалыг Мал хамгаалах санд хүргүүллээ.

2016-2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд мал бүхий иргэд 132506 тонн өвс бэлтгэхээс 09 дүгээр сарын 27-ны байдлаар 101297 тонн өвс бэлтгэж 80 хувьтай байна.

Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Орхон, Хушаат зэрэг сумдаас ирсэн мал амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө зөвлөмжийг өгч, хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаа мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний адууны махны 3 дээж, 450 кг, үхрийн махны 68 дээж, 12200 кг, хонины махны 113 дээж 2800 кг, ямааны махны 5 дээж 10 кг, гахай 1 дээж 60 кг, сүүний 7 дээж 350 л, дээжинд тус тус мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулалж гэрчилгээ олголоо.

Халдварт, паразиттах өвчний гаралт, тархалт, эмчлэн сэргийлэх арга хэмжээний вакцинжуулалтын ажил хугацааны дагуу аймгийн хэмжээнд хэвийн явагдаж байна.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Бруцеллёз өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд бод 29.4524, бог 398.040 мянган толгой мал хамруулах, ажлыг зохион байгуулж байна.

Долоо. Байгаль орчны чиглэлээр:

Ашигтмалтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчны гхамгаалах та лаархүлээсэнүүргийнхэрэгжилт, “Байгаль орчны гхамгаалах тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйл, “Байгаль орчны нөлөөлөх байдлын нүлгээний тухай” хуулийн 9.10, 9.11, 9.12 дах заалтыг мөрдөж ажиллаж байгаа эсэх, нөхөн сэргээхүүргээхэрэгжүүлж буй байдал дхяналт шалгалт хийх, газар дээр нь ажилласны үндсэндээ рүүссэн нөхцөл байдал ддүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор БОАЖЯ-ны Ой, Ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын гэрээт ажилтан, Хараа, Ерөө голын сав газрын захиргааны мэргэжилтэн, Ашигтмалтмал, газрын тосны газрын мэргэжилтэн, аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй Хүдэр, Ерөө сумдын нутаг дэвсгэрт ашигтмалтмалынашиг лалтын нүйлажиллагаа явуулж буй а жахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийсэн.

Германы Олон Улсын Хамтынажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн засаа чөлөөтөл бөрөөс Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 9-р сарын 20-ны өдөр “Уулуурхайн салбар дахиргэдийн оролцоо” сэдэвт сумын өдөрлөг зохион байгуулагдсан. Уг өдөрлөгт аймгаас Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлоготөлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Ойнал баны дарга, уулуурхайна суудал хариуцсан мэргэжилтэн нар оролцсон.

Засгийн газрын тусгай сангийн нүйлажиллагааны үрдүн” болон “Байгаль орчны гхамгаалах тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит тусгазарт хийгдэж байгаа тайх олбог дуулан аймгийн Аудитын газ арт 2014, 2015 оны тайлан, тайлангийн хавсралт, аймгийн Засаг даргын Байгаль орчны гхамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, БОНХАЖ Сайдтай байгуулсан гэрээ, гэрээний биелэлт, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчны гхамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилагдсан хөрөнгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зарцуулалт зэрэг материалуудой гоосбэлтгэсэн мод, ойн нөөц ашигласны төлбөрийн, усны зарцуулалт, усашигласны төлбөрийн, ховоранамь танаг насны, байгалийн нургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулалтын судалгааг зэргийг шалгуулахаар гаргаж өгсөн.

БОАЖЯ амболон Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвөөс хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол” сургалтанд хамрагдсан.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/185 тоот тушаалаар “Фторт нүүрс устөрөгч /ФНУ/НФС/ төрлийн хөргөх бодис болонозон дадалдаг бодисыг орлуулах бусад альтернатив бодис ын судалгаа тооллогынажлыг 17 суманд явуулсан. Тооллогоор R22, R130A бодисууд болональтернатив бодисуудын хэрэглээг бүртгэлжүүлсэн.



СЭЛЭНГЭ АЙМАГ

Байгальхамгаалахнамрынсарынаяныхүрээндгазрын 2016 оны 289 тоотоор “Бүхнийтийнихцэвэрлэгээ”-г аялалжуулчлалынгазруудад 2016 оны 08 дугаарсарын 26-ны өдрөөс 09 дүгээрсарын 26-ны өдөрхүртэлхугацаандзохионбайгуулжбайна. Тусаргахэмжээгээрамралт, сувилал, аялалжуулчлалынгазруудөөрийнээзмшлийнболонорчныбүсийнхогхаягдлыгбүрэнц эвэрлэж, хогийнсаавбайршуулах, хогхаягдалилзадгайхаяхгүйбайхталаарсурталчилгаанысамбарбайршуулахажлууд ыггүйцэтгэсэн.

Цэнгэгуснынөөц, байгальхамгаалахтөв /УТҮГ/-аасзохионбайгуулсан “Тогтвортойхөгжлийнболовсрол” төслийнхүрээндсалбарынажилтан, албанхаагчдыгТогтвортойхөгжил, Ногоонхөгжил, Тогтвортойхөгжлийнболовсролынүзэлбаримтлал, түүнийачхолбогдлынталаармэдээллээрхангах, чадавхижуулахсургалтандхамрагдсан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР